



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2004-2006 оны хөрөнгө оруулалтын үр дүн



**Үр нөлөө муутай хөрөнгө оруулалт
хийгджээ**

Улаанбаатар 2007 он

ҮАГ-2/2007/04-ГА

Агуулга

ҮАГ-ын Хоёрдугаар газар

Газрын захирал

О.Мэндбаяр

Аудитын менежер

Х.Баярмаа

Ахлах аудитор

Б.Сугар

Аудитор

Ц.Цэрэнхүү

Шинжээч

Б.Болормаа

2007 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын
вeб сайтаас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах
зүйл байвал 263813 дугаарын утас,
323266 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр, Бага
тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс

Товчилсон үгсийн жагсаалт 2

Аудитын зорилт, хамарсан хүрээ,
арга зүй 3

Бүлэг 1

Хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу хийгдээгүй байна

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө үндсэн
үйл ажиллагааны зорилттой нийцээгүй
байна 5
- Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө
оруулалтыг хийгээгүй байна 6
- Зарим ажлыг төлөвлөсөн төсвөөс
хэтрүүлэн санхүүжүүлсэн байна 7
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа
холбогдох хууль тогтоомж мөрдөөгүй,
тендергүй шалгаруулжээ 8
- Зарим аж ахуйн нэгж орлогын албан
татварыг дутуу төлжээ 10

Бүлэг 2

Хөрөнгө оруулалт үр дүн муутай байна

- Эдийн засгийн үр өгөөж муутай
хөрөнгө оруулалт хийжээ 11
- Төрийн өмчийн ашиглалтад тавих
хяналт хангалтгүй байна 12

Зөвлөмж 14

- Хавсралт 1 15

Товчилсон үгсийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
БАГСБТЖ	“Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”
ГТҮА	Газрын тусгай үйлчилгээний алба
СЯ	Сангийн яам
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ЗТАЖЯ	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
ОУНБ	Олон улсын нисэх буудал
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТБОНӨХХАБАҮГС	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ХБХХЗ	Хөөрч буух хатуу хучилттай зурвас
ХБШЗ	Хөөрч буух шороон зурвас
ЦТП	Цахилгаан түгээх подстанц
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийв.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2004-2006 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг шалгаж, дүгнэлт гаргах, үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитаар Сангийн яам, Зам тээвэр, аялал жуулчлалын яам, ИНЕГ, түүний харъяа байгууллага, хөрөнгө оруулалт, их засварын ажлын санхүүжилт авсан зарим аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг шалгалаа.

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгон ИНЕГ-ын холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу хийгдээгүй байна



1.1 ИНЕГ-ын стратегийн үндсэн зорилго нь нисэхийн аюулгүй ажиллагааг бүрэн хангасан эдийн засгийн үр ашигтай иргэний нисэхийн тогтолцоог бүрдүүлж, иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд оршино.

1.2 Уг зорилтыг хэрэгжүүлэхдээ шинэ технологи, тоног төхөөрөмжийг оновчтой сонгон нэвтрүүлэх замаар иргэний агаарын тээврийг хөгжүүлэх боломжийг судлан хэрэгжүүлж, олон улсын болон Монгол орны нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаснаар иргэний нисэхийн тогтолцоог хангах боломжтой гэж үзжээ.

1.3 ИНЕГ-ын даргаар 2006 оны 10 дугаар сар хүртэл М.Дагва, үлдэх хугацаанд С.Батмөнх нар тус тус ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө үндсэн үйл ажиллагааны зорилттой нийцээгүй байна

1.4 Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэмд тус газар салбарын хөгжлийн урт болон дунд хугацааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна гэж заасан байна.

1.5 ИНЕГ-т Европын сэргээн босголт, хөгжлийн банк болон Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслүүдийн хүрээнд Иргэний нисэхийн салбарыг 2004-2012 онуудад хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулсан боловч үүнийг ямар ч тушаал шийдвэрээр баталгаажуулаагүй байна.

1.6 ИНЕГ өөрсдийн үйл ажиллагааны хэрэгцээг тооцоолсон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг жил бүр Зам, тээвэр аялал, жуулчлалын сайдын тушаалаар батлуулдаг байна.

Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг стратеги төлөвлөгөөтэй харьцуулж үзвэл:

сая төгрөг

Арга хэмжээний нэр	2004 онд		2005 онд		2006 онд	
	стратеги төлөвлөгөө	батлагдсан төлөвлөгөө	стратеги төлөвлөгөө	батлагдсан төлөвлөгөө	стратеги төлөвлөгөө	батлагдсан төлөвлөгөө
Хөрөнгө оруулалт	26,438.2	7,790.1	19,973.2	5,405.5	14,885.6	6,850.0
Их засвар	760.0	694.0		1,126.3	285.0	1,203.0
Тоног төхөөрөмж	983.0	3,606.0	2,600.0	9,920.4	23,300.0	9,020.2
Нийт дүн	28,181.2	12,090.1	22,573.2	16,452.2	38,470.6	17,073.2

1.7 Хүснэгтээс үзэхэд 2004-2006 оны стратеги төлөвлөгөөнд тусгасан хөрөнгө оруулалтын арга хэмжээний 43,0-44,7 хувийг гүйцэтгэхээр жил бүрийн төлөвлөгөөнд тусган батлуулжээ.

1.8 Үүнээс үзэхэд ИНЕГ-ын 2004-2006 онд стратегийн төлөвлөгөө үндэслэл муутай хийгдэж, жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдахгүй байна. Тухайлбал, 2003-2005 оны стратеги төлөвлөгөөнд Өмнөговь аймгийн Даланзадгад хотын нисэх буудлыг шинэчлэн өргөтгөх хатуу хучилттай зурвас хийхэд 11.8 тэрбум зарцуулна гэж тусгасан боловч 2004-2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг буудлыг орон нутгийн зориулалттай нисэх буудал болгохоор шийдвэрлэж, барилга байгууламж, хөөрч буух зурвасыг хийхэд 16,8 тэрбум төгрөгийг батлуулсан байна.

1.9 Баян-Өлгий аймгийн нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас барихад 3,8 тэрбум төгрөг зарцуулахаар стратеги төлөвлөгөөнд тусгасан боловч 2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 6,0 тэрбум төгрөгөөр батлуулжээ.

1.10 Жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг зөв тооцоолж, салбарын хөгжлийн урт болон дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулж байх нь зүйтэй байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтыг хийгээгүй байна

1.11 2004 онд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө Дэд бүтцийн сайдын (хуучин нэрээр) 14 дүгээр тушаалаар 12,1 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 10,6 тэрбум төгрөгийг зарцуулж, төлөвлөсөн ажлын биелэлт 87.6 хувьтай байна.

1.12 ЗТАЖ-ын сайдын 2005 оны 159 дүгээр тушаалаар 2005 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 17,1 тэрбум төгрөгөөр батлагдаж, 4,9 тэрбум төгрөгийг зарцуулж, биелэлт 28,6 хувьтай байна.

1.13 Сангийн сайд, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 360/189 дүгээр тушаалаар 2006 оны хөрөнгө оруулалтыг 17,0 тэрбум төгрөгөөр батласнаас 8,5 тэрбум төгрөгийг зарцуулж, биелэлт 50.0 хувьтай байна.

ИНЕГ-ын 2004-2006 оны хөрөнгө оруулалтыг ангиллаар нь харуулбал:

Үзүүлэлт	2004 онд			2005 онд			2006 онд			
	Төлөвлөсөн	хэрэгжсэн	Хэрэгжээгүй	төлөвлөсөн	хэрэгжсэн	хэрэгжээгүй	төлөвлөгөө	хэрэгжсэн	хэрэгжээгүй	
Барилга, байгууламж	7,790.1	8,130.8		7,320.5	2,458.4		6,850.0	4,534.9		
Их засвар	694	613.6		929.3	1013.9		1,203.0	870.1		
тоног төхөөрөмж	3,606.0	1,910.4		8,872.6	1,430.1		9,020.2	3,161.7		
Дүн	Ажил	48	34	14	69	49	20	111	83	28
	зардал	12,090.1	10,654.8	1,435.3	17,122.4	4,902.4	12,220.0	17,073.2	8,566.7	8,506.5

1.14 2004-2006 онд 22,2 тэрбум төгрөгийн 62 төлөвлөсөн ажил дутуу хийгдсэн нь тэдгээрийн техник, эдийн засгийн үндэслэлийг бодитой тооцоогүйгээс шалтгаалсан бөгөөд улмаар төлөвлөсөн төсөв, үнэлгээ, гэрээний нөхцөл байдал өөрчлөгдөн, зарим тендерийн үйл ажиллагаа удааширч, хэрэгжээгүй байна.

Нийт хөрөнгө оруулалтад зарцуулсан хөрөнгийг зориулалтаар авч үзвэл:

Он	нисэхийн аюулгүй ажиллагаатай холбоотой		үйлчилгээ, аж ахуйтай холбоотой		Зөрүү	
	Ажлын тоо	Зардал	Ажлын тоо	зардал	ажлын тоо	зардал
2004	7	5,055.7	26	5,599.1	19	543.4
2005	15	1,215.9	34	3,686.5	19	2,470.6
2006	18	3,047.0	65	5,519.7	47	2,472.7
Дүн	40	9,318.6	125	14,805.3	85	5,486.7

1.15 Хүснэгтээс үзэхэд 2004-2006 онд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах хөрөнгө оруулалтаас аж ахуйн чиглэлийн хөрөнгө оруулалт 1,6 дахин буюу 5,5 тэрбум төгрөгөөр илүү хийгдсэн байна.

Зарим ажлыг төлөвлөсөн төсвөөс хэтрүүлэн санхүүжүүлсэн байна

1.16 Зарим ажлыг эрх бүхий байгууллагын зохицуулалт, шийдвэргүйгээр, батлагдсан төлөвлөгөөнөөс болон төсөвт өртгөөс илүү санхүүжүүлжээ.

Тухайлбал, Завхан аймаг дахь Донойн нисэх буудлын зогсоолыг хатуу хучилттай болгох ажлыг 239,5 сая, Хөвсгөл аймгийн Хатгал сум дахь хөөрч буух шороон зурвасын өргөтгөл, их засварын ажлыг 48,0 сая, Завхан, Сүхбаатар аймгийн нисэх буудлын ХБШЗ -ын ажлыг 15,7-36,9 сая, богино долгионы радио холбооны станцыг шинэчлэх ажлыг 385,9 сая, автомашин авах зардлыг 181,2 сая төгрөгөөр тус тус батлагдсан төсвөөс, Жаргалант дахь жуулчны баазын барилгын зардлыг 170.0 сая, Баянхонгор аймгийн хөөрч буух хатуу хучилттай зурвас(ХБХХЗ)-ын засварын зардлыг 104.3 сая, ОУНБ-ын перроны их засвар, өргөтгөлийн зардлыг 305.9 сая, Жаргалант дахь жуулчны баазаас Богд уулын локатор хүртэлх 2.7 км замын ажлын зардлыг 9.6 сая төгрөгөөр тендерийн төсөвт өртгөөс тус тус хэтрүүлэн санхүүжүүлсэн байна.

1.17 “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 8-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” гэж заасныг зөрчиж 2004 онд батлагдсан төсвийг хэтрүүлэн газрын тусгай албаны үйлчилгээнд зориулж 221,9 сая төгрөгийн 11 автомашиныг ТӨХ-ны зөвшөөрөлгүй худалдан авсан байна.

1.18 2004-2006 онд ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээр /орон сууц/ 1,520.0 сая төгрөг төлөвлөсөн боловч гүйцэтгэлийг 269,4 сая төгрөгөөр зөрүүтэйгээр тайлагнасныг аудитын явцад тогтоолоо.

он	Батлагдсан төлөвлөгөө	Санхүүжилт		Зөрүү
		гүйцэтгэлээр	аудитаар	
2004	440.0	820.0	1,224.4	404.4
2005	350.0	302.1	402.0	99.9
2006	730.0	281.0	163.0	-118.0
дүн	1,520.0	1,403.1	1,789.4	269.4

1.19 2004 оны төлөвлөгөөгөөр батлагдсан Өмнөговь аймгийн Даланзадгад хотод баригдах ОУНБ-ын барилгыг орон нутгийн буудлын зэрэглэлтэй болгосноос хэмнэгдсэн 362.6 сая төгрөгийг Сангийн сайдын 2004 оны 4-9а/3628 дугаар албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу ЗТАЖЯ-ны барилгын засвар хийх, тоног төхөөрөмж, тавилга худалдан авахад зарцуулсан боловч үүнийг ИНЕГ хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд оруулж тооцоогүй байна.

1.20 Цаашид стратеги төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулан мөрдөж ажиллах, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх шаардлагатай байна.

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй, тендер зарлаагүй байна

1.21 Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 218 дугаар тогтоол, ЗТАЖС-ын 2006 оны 172 дугаар тушаалаар Зам тээвэр, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, Барилга захиалагч, хөрөнгө оруулалтын хэлтэс нь Тендерийн материал бүрдүүлэлтийн тасаг, Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн тасаг болж зохион байгуулагджээ.

1.22 ИНЕГ-ын 2004-2006 онд худалдан авсан нийт 17,1 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу сонгосон эсэхийг шалгалаа.

1.23 ИНЕГ худалдан авах ажиллагаа тус бүрт тендерийн бичиг баримтыг холбогдох заавар, журмын дагуу бэлтгэж, тендерийн хороогоор батлуулан, гүйцэтгэгч сонгох ажиллагааг хуулийн дагуу хийж гүйцэтгэсэн боловч зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

1.24 Захиалагч байгууллага ТБОНӨХХАБАҮГСЖ-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д заасан төсөвт өртгийг харгалзан гүйцэтгэгч сонгохдоо нээлттэй болон хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аль нэгийг сонгож худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх ёстой.

1.25 2004 онд нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авах ёстой 2,0 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг хязгаарлагдмал тендер шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах аргаар худалдан авсан нь аудитад хамрагдсан нийт худалдан авалтын 18,9 хувийг эзэлж байна.

1.26 Хязгаарлагдмал тендер шалгаруулалтаар худалдан авах ёстой 1,2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээ байгуулах буюу нэхэмжлэхийг үндэслэж худалдан авчээ.

1.27 Энэ нь ТБОНӨХХАБАҮГСЖ-ын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д “Энэ хуулийн 4 дүгээр бүлэгт заасан онцгой журам хэрэглэх нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гүйцэтгэгч сонгох ажиллагааг 3 дугаар бүлэгт заасан нээлттэй тендер шалгаруулалтын журмыг үндэслэн явуулна” гэж заасныг зөрчсөн байна.

1.28 2004-2006 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын тендерийн үйл ажиллагааг түүвэрчлэн үзэхэд 17 төсөл, арга хэмжээний 3,262.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг тендер зарлалгүй шууд худалдан авч хууль зөрчжээ. (Хавсралт 1)

1.29 ТБОНӨБАҮХА тухай хуулийн 38 дугаар зүйлийн 3-т заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийг олон хэсэг хувааж яам дундын тендерийн хороогоор шийдвэрлэвэл зохих худалдан авах ажиллагааг яамны тендерийн хороогоор, яамны тендерийн хороогоор шийдвэрлэвэл зохих худалдан авах ажиллагааг агентлагийн тендерийн хороогоор шийдвэрлээгүй зөрчил нийтлэг байна. Тухайлбал, 2004-2005 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээг төсөвт өртгөөр нь авч үзвэл яам дундын тендерийн хороогоор шийдвэрлэвэл зохих 7, яамны тендерийн хороогоор шийдвэрлэвэл зохих 15 тендерийг ИНЕГ-ын Тендерийн хороо (агентлаг) шалгаруулсан байна.

1.30 “Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам”-ын 9 дүгээр бүлэгт зааснаар захиалагч байгууллага худалдан авах ажиллагаа тус бүрт хавтаст хэрэг нээж хөтлөн архивын нэгж болгон хадгалсан байх ёстой. Гэтэл 2004-2006 онд тендер зарлан нийт 171 байгууллагыг шалгаруулж, гэрээ байгуулснаас 60 хувь буюу 101 байгууллага худалдан авах ажиллагаа тус бүрт зохих журмын дагуу тендерийн материалыг бүрэн бүрдүүлээгүй, баримтын эмх цэгц муутай байв.

Зарим аж ахуйн нэгж орлогын албан татварыг дутуу төлжээ

1.31 Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд зарцуулсан хөрөнгө нь улсын төсвийн орлогод хэрхэн нөлөөлж байгааг тендерт шалгарсан зарим компаниудын татварын албанд өгсөн татварын тайлан, мэдээг бараа, ажил, үйлчилгээ нийлүүлж олсон орлоготой тулган баталгаажуулах замаар шалгахад:

- “Данс” ХХК 2006 оны 9 дүгээр сард ИНЕГ-ын дарга С.Батмөнхтэй “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ” байгуулж, “Ланд круйзер” автомашин 3 ширхгийг нийлүүлж 220.0 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч 1998 онд байгуулагдсанаас хойшхи хугацаанд огт үйл ажиллагаа явуулаагүй учир ямар нэгэн тайлан мэдээ гаргаагүй гэж харъяалагдах Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст албан бичиг хүргүүлсэн,
- “Экос” ХХК нисэх буудлын байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийхэд ИНЕГ-аас 46,1 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч 2005-2006 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар 23,8 сая төгрөгийн орлого олсон гэж тайлагнасан,
- “Ди энд Эн” ХХК ЗТАЖЯ-ны Тээврийн үйлчилгээний төвийн барилгын инженерийн шугам, сүлжээний ажлыг 150.0 сая төгрөгөөр хийх гэрээ байгуулан гүйцэтгэсэн боловч харъяалагдах Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст 2005 оны жилийн эцсийн борлуулалтын орлогоо 9,1 сая төгрөгөөр тайлагнасан,

- “ЦБА аялал” ХХК 144.8 сая төгрөгөөр ИНЕГ-т барилгын засварын ажил гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч 2005 оны татварын орлогоо 16.8 сая төгрөгөөр тайлагнасан байв.

1.31 Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтээс улсын төсөвт эргэж төлөгдөх ёстой татвар, хураамж болон бусад төлбөр бүрэн хэмжээгээр төвлөрөхгүй байгааг харуулж байна.

Бүлэг 2

Хөрөнгө оруулалт үр дүн муутай байна

2.1 “Иргэний нисэхийн тухай” хуулийн 8.4.5-д “Иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах” гэж заасан байдаг.

Эдийн засгийн үр өгөөж муутай хөрөнгө оруулалт хийжээ

2.2 Байгаль, цаг уур, техникийн шалтгаанаар агаарын хөлөг цагийн хуваариар нисэх боломжгүй үед хилийн бүсийн бүртгэлд хамрагдсан зорчигчдод транзит үйлчилгээ үзүүлэх зорилгоор Жаргалант аманд “Аялал жуулчлалын транзит үйлчилгээний цогцолбор” байгуулахаар төлөвлөж, Засгийн газрын 2003 оны 260 дугаар тогтоол, Байгаль орчны яамны Улсын тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт газар ашиглах 2003 оны 068 дугаар гэрчилгээ гаргуулан авчээ.

2.3 Төрийн өмчийн хороо 2004 оны 250 дугаар тогтоолоор “Буянт-Ухаа жуулчны транзит үйлчилгээний барилга барих ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг ИНЕГ-ын харъяа Буянт-Ухаа ОУНБ-д зөвшөөрсөн байна.

2.4 2003-2004 онд Буянт-Ухаа ОУНБ-аас 16 гэр-зочид буудал болон холбогдох дэд бүтцийг барихад 2,122.0 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвөөс илүү санхүүжүүлжээ. Цогцолборын 2 дахь хэсэг болох 7 давхар зочид буудлын барилгыг ИНЕГ ямарч батлагдсан эх үүсвэргүй, ТӨХ-ны зөвшөөрөлгүйгээр “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 24 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг зөрчин, “Ханрим” ХХК-тай гэрээ байгуулан 2,070.000 ам доллар буюу 2,512.9 сая төгрөгөөр худалдан авчээ.

2.5 2004-2006 онд Буянт-Ухаа хотхонд нийт 5,404,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн боловч төлөвлөсөн хэмжээнд үйл ажиллагаа явуулаагүйгээс 2005-2006 онд 160.3-610.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ хугацаанд Улаанбаатар-Берлин-Милан чиглэлийн нислэг 2 хоног саатаж, 45 зорчигч байрласныг эс тооцвол нислэгийн транзит үйлчилгээ явуулаагүй байна.



Төрийн өмчийн ашиглалтад тавих хяналт хангалтгүй байна

2.6 “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 3-д “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.



2.7 ИНЕГ-ын ашиглалтын зөвшөөрөлтэй улсын тусгай хамгаалалттай Жаргалантын аманд “Ханрим” ХХК гэр бүлийн зориулалттай 20 байрыг барьж, хувь хүмүүст худалдсан бөгөөд барилгын подвалд байрлах 40 автомашины дулаан гражийн зургийн үнэ 3.7 сая, цахилгааны засварын 3.2 сая, Улсын тусгай хамгаалалттай газрын түрээсийн төлбөр 3.1 сая, цахилгааны зардалд 3.3 сая, цэвэр, бохир усны төлбөр 1.5 сая, улаан шугам татсан ажлын хөлс 0.9 сая, нийт 15,7 сая төгрөгийг хувь хүмүүсийн

өмнөөс Буянт-Ухаа ОУНБ-аас төлсөн байна. Иймд байгууллагын хохиролгүй болгож, зөрчлийг арилгах нь зүйтэй гэж үзлээ.

2.8 2004 онд цайны газрыг 14.8 сая төгрөгөөр засварласан боловч ТӨХ-ны 2006 оны 526 дугаар тогтоолын дагуу уг объектыг ашиглахгүй, нураахаар болжээ



2.9 2005 оны ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын 13 тоот шийдвэрийн дагуу иргэн Б.Чулуунцэцэгт Иргэний нисэхийн ерөнхий газрын хөрөнгөнд бүртгэлтэй 21.5 сая төгрөгийн орон сууцыг гэрээний үндсэн дээр үнэ төлбөргүй ашиглуулж байна.

2.10 2006 онд улсын төсвийн хөрөнгөөр “Данс” ХХК-наас худалдан авсан нийт 220.0 сая төгрөгийн 3 ширхэг “Ланд круйзер”

автомашин ИНЕГ-т бүртгэлтэй боловч ТТХГ-ын автобаазад давхар бүртгэгдэж тус газар ашиглаж байна. Энэ асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

2.11. Дээрх байдлаас үзэхэд ИНЕГ-т хөрөнгийн ашиглалт, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.12 Сангийн сайд, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2006 оны 360/ 189 дүгээр тушаалаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл болон санхүүжилтийн биелэлтэнд байнга хяналт тавьж ажиллахыг СЯ, ЗТАЖЯ, ИНЕГ-т тус тус үүрэг болгосон байна.

Үүний дагуу Сангийн яам, ЗТАЖЯ-наас хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд шалгалт хийж, шийдвэр гаргасан боловч түүний мөрөөр хийсэн ажлын үр дүн гараагүй, илэрсэн зөрчил дутагдал давтан гарсаар байгаа нь яамнаас тавьж буй дотоод хяналт үр дүн муутайг харуулж байна.

2.13 Үндэсний аудитын газраас 2006 онд ИНЕГ, СЭЗЯ-ны хооронд байгуулсан дамжуулан зээлдүүлэх 1256 MON /SF/ 1370 MON/SF/ гэрээний биелэлтэд аудит хийж, олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсын Засгийн газрын авсан зээлийн хүрээнд дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг тусгай дансанд төвлөрүүлэхийг Сангийн сайдад зөвлөмж болгосон боловч өнөөг хүртэл гэрээг байгуулаагүйгээс зөвлөмж хэрэгжээгүй байна.

2.14 УМХГ-аас ажилчин, албан хаагчдад орон сууц олгосон байдлыг шалгаж “Ундруул” ХХК-наас худалдаж авсан орон сууцыг гэрээнд заагдсан талбайнаас илүү тооцож төлсөн 46.2 мянган ам. долларыг улсын төсвийн орлого болгохыг ИНЕГ-ын дарга С.Батмөнх, нягтлан бодогч Г.Наранцэцэг нарт хариуцуулан акт тогтоосон боловч өнөөг хүртэл төлбөрийг барагдуулаагүй байна.

Зөвлөмж



Аудитын дүнд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна:

Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэлд:

- Хөрөнгө оруулалтын үр нөлөөг дээшлүүлэх, ашиглалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, төлөвлөгөөнөөс гадуур хөрөнгө оруулалт хийсэн холбогдох хүмүүст хариуцлага тооцох

ИНЕГ-ын дарга С.Батмөнхөд:

- Үндсэн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтыг төлөвлөн мөрдөж ажиллах
- “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байх
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Сангийн сайдын 2006 оны 395 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвөөс хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх

Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зоригтод:

- Татвар ногдох орлогыг үнэн зөв тодорхойлоогүй байгууллагад холбогдох хуулийн дагуу татварыг ногдуулж нөхөн төлүүлэх

ИНЕГ-ын 2004-2006 онд тендер зарлаагүй худалдан авсан
бараа, ажил үйлчилгээний судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (сая төгрөг)	Гүйцэтгэчийн нэр
<u>2004 онд</u>			
1	Баян-Өлгий нисэх буудлын барилга, байгууламж	953.4	“Жол” ХХК
2	ИНЕГ-ын тусгай үйлчилгээний албаны контторын барилгын засвар	9.2	“Хүжийн гал” констракшн
3	Баян-Өлгийн аймгийн нисэх буудлын хаяг	6.4	“Декора” ХХК
4	ИНЕГ-ын цайны газрын засвар, цахилгааны ажил	16.6	“Гантүшиг” ХХК
5	Байгалийн үзэгдлийн улмаас Донойн Нисэх буудалд учирсан хохирлыг сэргээн засварлах	13.0	“Цо Би А”
6	Хөвсгөл Хатгал нисэх буудлын аэродромын торон хашаа	17.7	Хөвсгөл НБ
7	ГТҮА-ын шатахуун түгээврийн саравч хийх	5.1	“Хүжийн гал” констракшн
8	Ховдын Булган сумын асфальт бетон хучилттай зам	21.6	“Ховдын өргөө” ХХК
9	ИНЕГ-ын гол хаалга солих	7.1	“Алтан ус” ХХК
10	Халаалтын ус цэвэршүүлэгч ЦТП	9.7	“Хидро икс Монголия” ХХК
11	Халаалтын ус цэвэршүүлэгч ЦТП 2005	8.5	“Хидро икс Монголия” ХХК
<u>2005-2006 онд</u>			
12	Баян-Өлгий аймгийн нисэх буудлын байгаль орчны үнэлгээ хийлгэх	14.7	Экос” ХХК
13	Чингис хаан Олон улсын буудал, Хөвсгөл аймгийн шатахууны агуулах” төсөл, Завхан, Баян-Өлгийн нисэх буудлын төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	31.4	Экос
14	Хөдөө ажлын зориулалттай автомашин худалдан авах	220.1	“Данс”ХХК
15	Ханрим зочид буудал, үйлчилгээний төвийн тавилга, тоног, төхөөрөмжийн ажил	100.0	“Олирус” ХХК, Цогт билгүүн, Монтаун ХХК
16	“Жаргалант хотхон”-ны үйлчилгээний төв, зочид буудалд хийсэн ажил	217.0	
17	Аялал жуулчлалын транзит цогцолборт барилга, засварын ажил	1,610.8	Буянт-Ухаа ОУНБ
	Дүн	3,262.3	

ТУШААЛ

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. ИНЕГ-ын 2004-2006 оны хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороо, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, ИНЕГ-ын дарга С.Батмөнх, ҮТЕГ-ын дарга Л.Зоригт нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2007 оны 10 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын Ц.Цэнгэл, ИНЕГ-ын дарга С.Батмөнх, ҮТЕГ-ын дарга Л.Зоригт нарт зөвлөсүгэй.

Тав. Аудитын зөвлөмж, албан шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хоёрдугаар газрын захирал О.Мэндбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

ИНЕГ-ын 2004-2006 оны хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөрчлийн жагсаалт

төгрөгөөр

№	Байгууллагын нэр	Төлбөр хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
		Нэр	Албан тушаал			
1	Иргэний нисэхийн ерөнхий газар	С.Батмөнх	ИНЕГ-ын дарга	“Ханрим” ХХК Жаргалантын аманд гэр бүлийн зориулалттай 20 байрыг барьж, хувь хүмүүст худалдсан ба цахилгааны засвар, Улсын тусгай хамгаалалттай газрын түрээс, цахилгаан, цэвэр, бохир усны төлбөр, улаан шугам татсан ажлын хөлс, нийт 12.0 сая төгрөгийг хувь хүмүүсийн өмнөөс төлсөн	02	12,000,000.0
		Г.Наранцэцэг	Ерөнхий нягтлан бодогч			
	Дүн					12,000,000.0

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР